

“БУЯНЫ ЗАН ҮЙЛИЙН ХОЛБОО” ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.“БУЯНЫ ЗАН ҮЙЛИЙН ХОЛБОО” нь гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага байна.

1.2. Буяны зан үйлийн холбоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай болон бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллана.

1.3 Холбооны оноосон нэр: “БУЯНЫ ЗАН ҮЙЛИЙН ХОЛБОО” ТББ (товчоор “БЗҮХ” ТББ) Англиар: “MONGOLIAN FUNERAL ASSOCIATION” (товчоор “MFA” NGO)

1.3.Тус холбоо нь өөрийн бэлгэдэл, тамга тэмдэг, данс, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.4.Холбооны хууль ёсны байршил, хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж 9/1 Нью майнд ХХК-ийн байр, 301 тоот

- Шуудангийн хайрцаг №181
- Е майл хаяг: info@mfa.mn
- Харилцах утас: 77117997

Хоёр.Төрийн бус байгууллагын зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл

2.1. “Буяны зан үйлийн холбоо” ТББ (цаашид “Холбоо” гэх)-ын зорилго нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг дээдлэх, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангах талаар төрийн бодлогыг дэмжиж хамтран ажиллах, талийгаачийг хөдөөлүүлэх уламжлалт зан үйл, олон улсын нийтлэг жишгийг олон нийтэд зөв тайлбарлан таниулах, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох талаар судалгаа явуулж санал боловсруулах, оршуулга, буяны зан үйлийн (цаашид “Салбар” гэх) үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагуудыг шаардлагатай мэдээлэл, аргачилсан удирдамжаар хангах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, буяны зан үйлийн талаар олон нийтэд мэдээлэл

түгээх, таниулах, тохирлын үнэлгээ хийх, үйл ажиллагаануудыг явуулах, оршуулгын үйлчилгээний мэргэжлийн ажилтан бэлтгэх мэргэжлийн холбоо болно.

2.2. Холбоо нь үйл ажиллагаандаа уламжлал, шинэчлэлийг хослуулах, гишүүддээ тэгш, шударга, нээлтэй байх зарчмыг баримталж, олон улсад танигдсан нэр бүхий, хараат бус, бие даасан мэргэжлийн холбоо байхыг зорьж ажиллана.

2.3. Зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараахь үйл ажиллагааг явуулна:

2.3.1.Салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, оршуулгын үйлчилгээний таатай орчинг бий болгох чиглэлээр төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, бусад байгууллагатай хамтран ажиллаж, салбарын хэмжээнд бодлого боловсруулахад идэвхтэй оролцох;

2.3.2.Төрийн болон орон нутгийн байгууллагын зарим чиг үүргийг нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

2.3.3.Салбарын хөгжлийг хангах чиглэлээр стандарт, дүрэм журам боловсруулах, хэрэгжилтийг хангах;

2.3.4.Салбарын хэмжээнд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын дунд уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, тухайн байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагааг сайжруулах;

2.3.5.Салбарын хэмжээнд үйлчилгээ болон мэргэжлийн ур чадвар, бүтээгдэхүүний чанар, үйлчилгээний түвшинг дээшлүүлэх зорилгоор сургалт, семинар, хэлэлцүүлэг, уралдаан тэмцээн зохион байгуулах, холбогдох материалаар хангах;

2.3.6.Тус холбооны гишүүдийн эрх ашгийг хамгаалах, гишүүд хооронд харилцан туршлага солилцож хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх, гишүүдийг холбогдох хууль тогтоомж, салбарын бодлого, чиглэлийн талаарх мэдээллээр хангах;

2.3.7.Нас барагсдыг нутаглуулах уламжлалт зан үйл, олон улсын нийтлэг жишгийг судлан нийтэд зөв тайлбарлан таниулах;

2.3.8.Буяны зан үйлтэй холбоотой судалгаа, шинжилгээний ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, үр дүнг тооцон олон нийтэд болон гишүүддээ тогтмол мэдээлж байх;

2.3.9.Ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг оршуулгын байгууллага, Олон улсын оршуулгын холбоод, түүнчлэн оршуулгын зан үйл, ёс заншилын талаар судалгаа хийдэг эрдэм шинжилгээ, судалгааны болон шашны байгууллага, судлаачидтай холбоо тогтоож, хамтран ажиллах, харилцан туршлага солилцох;

2.3.10.Холбооны гишүүд төлөөлөгчдийг дээрх байгууллагаас зохион байгуулах хурал, уулзалт, үзэсгэлэнгийн үйл ажиллагаанд оролцуулах, түүнчлэн хилийн чанад дахь түншлэгч байгууллагын төлөөлөгчдийг урьж, ажил хэргийн уулзалт, сургалт-семинар зохион байгуулж байх;

2.3.11.Буяны зан үйлийг гүйцэтгэхэд шаардагдах байгаль экологид хоргүй эд материал, техник технологи, дэвшилтэд программ хангамжийг судалж оршуулгын үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудыг мэдээллээр хангах;

2.3.12. Салбарын болон Гишүүдийн эрх ашгийг төлөөлөн Төрийн болон холбогдох бусад эрх бүхий байгууллагатай харилцах, хамтран ажиллах;

2.3.13 Салбарын болон Гишүүдийн эрх ашгийг төлөөлөн Шүүх, эрх бүхий байгууллагад гомдол, нэхэмжлэл гаргах, нэхэмжлэгчээр оролцох;

2.3.14.Иргэдийн хүсэлтийн дагуу тус улсад нас барсан гадаадын иргэний шарилыг нутагт нь хүргэх, хилийн чанадад нас барсан тус улсын иргэний шарилыг эх оронд нь авчрахад дэмжлэг үзүүлэх, шаардлага гарвал хилийн чанад дахь түншлэгчдээс туслалцаа хүсэх;

2.3.15.Үйл ажиллагааныхаа чиглэлээр тодорхой хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх;

2.3.16. Гишүүд болон олон нийтийг үндэслэлтэй, үнэн бодит, шинжлэх ухаанч мэдээлэл, мэдлэгээр хангах;

2.3.17. Гишүүдийнхээ мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх, бусдаас суралцах, мэдээлэл солилцох боломжоор тогтмол хангах;

2.3.18. Холбооны үндсэн үйл ажиллагаа, зорилготой нийцсэн бусад төрлийн үйл ажиллагаа.

Гүрав.Төрийн бус байгууллагын гишүүнчлэл

3.1.Холбооны дүрэм, зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хүлээн зөвшөөрч буй хувь хүн, байгууллага сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсэнэ. Тус Холбоо нь Үндсэн, Дэмжигч болон **Хүндэт гишүүн** (цаашид хамтад нь “Холбооны гишүүн” гэх)-тэй байна.

3.2. Холбооны гишүүн элсүүлэх тухай шийдвэрийг гишүүнээр элсэх өргөдлийг үндэслэн Гүйцэтгэх захирал гаргах бөгөөд Үндсэн гишүүний хувьд гишүүний татвар төлснөөр гишүүний бүрэн эрх нь баталгаажна. Үндсэн гишүүн нь гишүүнээр элсэх эхний улирлын татвараа төлөөгүй, эсхүл бүх гишүүдийн хурал болох үед 2 болон түүнээс дээш улирлын татвараа төлөөгүй бол бүх гишүүдийн хуралд оролцох эрхгүй буюу саналын эрх эдлэхгүй.

3.3.Үндсэн гишүүнд буяны үйл ажиллагаа эрхэлж байгаа болон оршуулгын үйл ажиллагаатай холбоотой бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлж буй зөвхөн **хуулийн этгээд** байх бөгөөд дараах эрх, үүрэгтэй байна:

3.3.1.Холбооны үйл ажиллагаанд тэгш эрхтэйгээр оролцох, санал, хүсэлт, гомдол гаргах, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

3.3.2.Холбооны удирдлага, бусад албан тушаалд өөрийн болон бусдын нэрийг дэвшүүлж сонгох, сонгогдох, хуульд заасан үндэслэлээр болон өөрийн хүсэлтээр сонгогдохоос татгалзах;

3.3.3.Холбооны үйл ажиллагааны тухай мэдээлэл, бусад материалтай танилцах;

3.3.4.Холбооны үйл ажиллагаатай холбоотой журам, бусад шийдвэрийн төсөл санаачлах;

3.3.5.Холбооны үйл ажиллагаатай холбогдох асуудлаар санал, санаачилга гаргах;

3.3.6.Холбооноос зохион байгуулсан хурал, семинар, зөвлөлгөөнд оролцох, мэдээлэл авах;

3.3.7.Холбооноос явуулж буй арга хэмжээнд давуу эрхтэйгээр эхний ээлжинд оролцох, үндсэн гишүүний хөнгөлөлт, давуу эрх эдлэх;

3.3.8.Мэргэжлийн болон бусад чиглэлээр сургууль, дамжаанд хамрагдах, элсэхэд Холбооноос тодорхойлолт авах болон бусад асуудлаар дэмжлэг хүсэх;

3.3.9.Холбооны дүрэм болон Холбооноос гаргасан шийдвэр, дүрэм, журмыг дагаж мөрдөх;

3.3.10.Холбооны үйл ажиллагаанд оролцох, Холбооноос өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;

3.3.11.Холбооны нэр хүндийг эрхэмлэж, удирдах байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх;

3.3.12.Гишүүний татвараа хугацаанд нь бүрэн төлөх;

3.3.13.Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас Холбоонд учруулсан бодит хохирлыг хуульд заасан журмын дагуу хувийн хөрөнгөөр нөхөн төлөх;

3.3.14.Удирдах зөвлөлд санал, хүсэлт, гомдол гаргах;

3.3.15.Хууль тогтоомжид заасан бусад эрх.

3.4.Дэмжигч гишүүнд шашны болон сургалт, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд байх ба дараах эрх, үүрэгтэй байна:

3.4.1.Холбооны үйл ажиллагаа болон салбарын тухай мэдээллээр үнэ төлбөргүй хангагдах;

3.4.2. Дэмжигч гишүүн нь гишүүний татвараас чөлөөлөгдөх буюу төлөхгүй бөгөөд тус холбооны үйл ажиллагааг дэмжих зорилгоор хандив тусламж үзүүлж болно;

3.4.3. Өөрийн санал, хүсэлтээр Холбооны үйл ажиллагаатай танилцах;

3.4.4. Холбооны үйл ажиллагааг сайжруулах, хөгжүүлэх, гишүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хүрээнд санал, санаачилга гаргах;

3.4.5. Холбооны болон салбарын үйл ажиллагаатай холбоотой зөвлөмж, судалгааг Холбоонд ирүүлж байх;

3.4.6. Дэмжигч гишүүн нь Холбооны бүх гишүүдийн хуралд төлөөлөгчөөр оролцох бөгөөд саналын эрх эдлэхгүй.

3.5. Хүндэт гишүүнд нэр дэвшигчийг Холбооны Ажлын албанаас тодорхойлж, хүндэт гишүүнээр бүртгэх эсэхийг Удирдах зөвлөл шийдвэрлэх бөгөөд хүндэт гишүүнд Холбооны чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд үлэмж хэмжээний үүрэг гүйцэтгэсэн, Холбооны эрх ашгийг хамгаалагч, нийгэмд нэр төр, алдар хүнд бүхий гадаад, дотоодын иргэн байх (Шашны, эрдэм шинжилгээ судалгааны, урлаг соёлын байгууллагын төлөөлөл, тэргүүн зэрэг) ба дараах эрх, үүрэгтэй байна:

3.5.1. Гишүүний татвараас чөлөөлөгдөх буюу татвар төлөхгүй байх;

3.5.2. Холбооны бүх гишүүдийн Хурлын төлөөлөгч байх бөгөөд саналын эрх эдлэхгүй;

3.5.3. Холбооны үйл ажиллагааг нийтэд сурталчлан таниулах;

3.5.4. Холбооны үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллах.

3.5.5. Холбооны зорилго, зорилтыг дэмжих, хэрэгжүүлэх, үйл ажиллагааг зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх талын арга хэмжээ авах, дэмжлэг туслалцаа үзүүлэх;

3.6. Холбооны гишүүнд дараах зүйлсийг хориглоно:

3.6.1. Өөрт эрх олгогдоогүй асуудлаар Холбоог төлөөлж мэдэгдэл хийх, үйл ажиллагаа явуулах;

3.6.2. Холбооны нэр, нэр хүнд, эд хөрөнгийн хувийн болон холбооны үйл ажиллагаа хэрэгжүүлэхээс бусад зорилгоор ашиглах, гишүүнчлэлийн эрхээ урвуулан ашиглах;

3.6.3. Холбооны дотоод мэдээлэл, байгууллагын нууцыг задруулах, хувийн болон бусад зорилгоор ашиглах;

3.6.4. Холбоотой ашиг сонирхлын зөрчилтэй үйл ажиллагаа явуулах, түүнд оролцох;

3.6.5. Холбоо, түүний гишүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг үйл ажиллагаа явуулах;

3.6.6. Холбоог татан буулгах, хуваах, тусгаарлах, нэгтгэх, нийлүүлэх зорилгоор аливаа үйл ажиллагаа явуулах;

3.6.7. Хууль тогтоомж болон энэхүү дүрмээр хориглосон бусад.

3.7. Холбоонд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно;

3.7.1.Холбооны зорилгод нийцээгүй аливаа үйл ажиллагаа эрхлэх;

3.7.2.Улс төрийн үйл ажиллагаа эрхлэх, сурталчлах;

3.7.3.Шашин шүтлэг, итгэл үнэмшлээр ялгаварласан аливаа төрлийн үйл ажиллагаа явуулах;

3.7.4.Хууль тогтоомж болон энэхүү дүрмээр хориглосон бусад зүйл.

3.8. Дараах тохиолдолд Холбооны гишүүнчлэлийг цуцлах буюу гишүүнээс хасах бөгөөд тухайн шийдвэрийг Холбооны Бүх гишүүдийн хурлаас гаргана:

3.8.1.Холбооны гишүүн нь гишүүний татвараа 2 болон түүнээс дээш улирал төлөөгүй;


3.8.2.Энэхүү дүрэмд заасан хориглох зүйлийг зөрчсөн;

3.8.3.Энэхүү дүрэм болон хууль тогтоомжид заасан бусад;

Дөрөв.Төрийн бус байгууллагын удирдлага, бүтэц, зохион байгуулалт

4.1. Холбооны удирдах дээд байгууллага нь бүх гишүүдийн Хурал байх бөгөөд Хурлын чөлөөт цагт Удирдах зөвлөл, өдөр тутмын үйл ажиллагааг Холбооны Тэргүүн, Гүйцэтгэх захирал удирдан зохион байгуулна.

4.2.Холбооны тэргүүн нь Удирдах Зөвлөлийн дарга байх ба Удирдах зөвлөлөөс 4 жилийн хугацаатай сонгогдоно.



4.3. Холбооны эрх барих дээд байгууллага Бүх гишүүдийн хурал байна. Бүх гишүүдийн хурал нь ээлжит, ээлжит бус байх бөгөөд ээлжит хурлыг жилд 2 удаа хийнэ. Бүх гишүүдийн ээлжит болон ээлжит бус хурлыг хуралдуулах хугацаа, товыг Удирдах зөвлөлөөс тогтооно.

4.4. Бүх гишүүдийн хурал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.4.1.Холбооны бодлогыг тодорхойлж, стратегийг хэлэлцэн батлах;

4.4.2.Нэгдсэн тайланг хэлэлцэж, үнэлэлт өгөх;

4.4.3.Холбоог өөрчлөн байгуулах, татан буулгах;

4.4.4.Холбооны удирдах зөвлөлийг байгуулах, удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, шинэ гишүүнийг сонгох;

4.4.5.Бүх гишүүдийн хурал үндсэн гишүүдийн 51-ээс дээш хувийн ирц бүрдсэнээр хүчин төгөлдөр болно;

4.4.6.Бүх гишүүдийн хурал ирц хүрээгүй шалтгаанаар хойшилсон бол хойшлогдсон хуралд үндсэн гишүүдийн 30 –аас дээш хувийн ирц бүрдсэнээр хүчин төгөлдөр болно;

4.4.7.Бүх гишүүдийн хурал тогтоосон дэгийн дагуу явагдана.

4.4.8.Бүх гишүүдийн хурлын шийдвэр хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн (51-ээс дээш) саналаар хүчин төгөлдөр болно.

4.4.9.Хууль тогтоомж болон энэхүү дүрэмд заасан бусад.

4.5. Бүх гишүүдийн хуралд Үндсэн гишүүд дараах саналын эрхтэйгээр оролцоно:

4.5.1. 10 хүртэл ажилтантай гишүүн-1 санал;

4.5.2. 11-35 хүртэл ажилтантай гишүүн-2 санал;

4.5.3. 36-74 хүртэл ажилтантай гишүүн-3 санал;

4.5.4. 76-150 хүртэл ажилтантай гишүүн-4 санал;

4.5.5. 151-с дээш ажилтантай гишүүн-5 санал;

4.6. Гишүүн хуулийн этгээдийн ажилтны тоог нийгмийн даатгалын төлөлт болон тайланг үндэслэн тодорхойлно.

4.7.Удирдах зөвлөл нь 11 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- Удирдах зөвлөлийн дарга-1
- Улаанбаатар хотын захиргаа-1
- Байгаль орчны салбар-1
- Мэргэжлийн хяналтын байгууллага-1
- Шүүх эмнэлэг-1

- Эрдэмтэн судлаач-1
- Орон нутгийн төлөөлөл-1
- Оршуулгын үйлчилгээ /далд/-2
- Оршуулгын үйлчилгээ /чандар/-1
- Оршуулгын бүтээгдэхүүн үйлчилгээ-1.

Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 4.7.1.Удирдах зөвлөлийн даргыг сонгох, чөлөөлөх, тайланг хэлэлцэх;
- 4.7.2.Холбооны хэтийн зорилго, стратегийг хэрэгжүүлж, тогтвортой ажиллахад бүх талын дэмжлэг үзүүлж, удирдлагаар хангах;
- 4.7.3.Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- 4.7.4.Холбооны жилийн төсөв батлах;
- 4.7.5 Гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх, тайланг хэлэлцэх;
- 4.7.6.Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, түүний төсвийг батлах;
- 4.7.7.Хууль болон дүрэмд заасан бусад бүрэн эрх.

4.8.Удирдах зөвлөлийн гишүүд хамтын шийдвэр гаргах ба бүрэн эрхээ хурлаар хэрэгжүүлнэ.

- 4.8.1.Удирдах зөвлөл улиралд 1-ээс доошгүй удаа хуралдах ба Удирдах зөвлөлийн гишүүн бүр саналын нэг эрхтэй байна.
- 4.8.2.Ээлжит бус хурлыг Удирдах зөвлөлийн даргын шийдвэрээр, Гүйцэтгэх захирлын шийдвэрээр, эсхүл Удирдах зөвлөлийн гуравны нэгээс доошгүй гишүүдийн хүсэлтээр зарлан хуралдуулж болно.
- 4.8.3.Удирдах зөвлөлийн хурал гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөр болно;
- 4.8.4.Удирдах зөвлөлийн хурал ирц хүрээгүй шалтгаанаар хойшилсон бол хойшлогдсон хуралд гишүүдийн 30 –аас дээш хувийн ирц бүрдсэнээр хүчин төгөлдөр болно;
- 4.8.5.Удирдах зөвлөлийн хурлын шийдвэр хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн (51-ээс дээш) саналаар хүчин төгөлдөр болно.
- 4.8.6.Удирдах зөвлөлийн шийдвэр нь тогтоол байна. Удирдах зөвлөлийн тогтоолд Удирдах зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 4.8.7.Удирдах зөвлөлийн хурал хийсэн тухай бүр хурлын тэмдэглэл хөтөлнө.
- 4.8.8.Удирдах зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийн талаар зарчмын өөр саналтай гишүүний тайлбарыг хурлын тэмдэглэлд хавсаргана.

4.8.7. Удирдах зөвлөл нь хувь хүний асуудлыг нууцаар, бусад асуудлыг илээр санал хураах зарчмаар шийдвэрлэнэ.

4.6. Удирдах зөвлөлийн дарга буюу Тэргүүний эрх, үүрэг:

4.9.1. Холбоог гадаад, дотоодод төлөөлөх;

4.9.2. Удирдах зөвлөлийн хуралдааны товыг зарлах, хуралдааныг даргалах;

4.9.3. Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах;

4.9.4. Холбооны ажлыг чиглүүлэн удирдах, бодлого боловсруулах, ажлын албаны үйл ажиллагаанд хяналт тавих.

4.10. Гүйцэтгэх захирал нь дараах үйл ажиллагааг явуулна:

4.10.1. Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд Холбоог итгэмжлэлгүйгээр төлөөлөх, өмч хөрөнгийг захиран зарцуулах;

4.10.2. Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай удирдан зохион байгуулах бөгөөд дэргэдээ ажлын албатай байна;

4.10.3. Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийн хугацаа, түүний эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага, цалин урамшуулал зэрэг асуудлыг Удирдах зөвлөлийн даргатай хийх гэрээгээр нарийвчлан зохицуулна.

4.10.4. Холбооны төсөл хөтөлбөр, сургалт семинарыг санаачлах;

4.10.5. Шаардлагатай гэж үзвэл Удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулах;

4.10.6. Удирдах зөвлөл, Удирдах зөвлөлийн дарга буюу Холбооны тэргүүний бүрэн эрхэд хамаарахаас бусад асуудлаар Холбоог удирдах;

4.10.7. Хууль, гэрээнд заасан бусад эрх, үүрэг.

4.11. Хяналтын Зөвлөл

4.11.1. Холбоо нь Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаа болон Холбооны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх Хяналтын зөвлөлтэй байж болно.

4.11.2. Хяналтын зөвлөл байгуулсан тохиолдолд тус зөвлөл нь 3 гишүүнтэй байна. Гүйцэтгэх захирал болон түүний удирдлагын багийн гишүүдийг Хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгохгүй.

4.11.3. Удирдах зөвлөлийн шийдвэрээр Хяналтын зөвлөлийн гишүүдийг нэг жил хүртэл хугацаатайгаар томилох буюу улируулан томилж мөн үүргээс нь чөлөөлж болно.

Тав. Төрийн бус байгууллагын санхүүжилт

5.1. Холбооны орлого нь дараахь эх үүсвэрээс бүрдэж болно:

5.1.1. Дүрэмд заасан үйл ажиллагаанаас олсон орлого;

5.1.2. Гишүүний татвар, хандив;

5.1.3. Зээлийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын болон орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгө;

5.1.4. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив.

5.2 Холбооны зарлага:

5.2.1. Холбоо нь орлогоо энэхүү дүрэмд заасан зорилго, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд зарцуулна;

5.2.2. Холбоо нь орлогоосоо ногдол ашиг хуваарилах, иргэн аж ахуйн нэгж, байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн төлбөрийг төлөхийг хориглоно;

5.2.3. Холбооны Удирдах Зөвлөлийн гишүүд, Тэргүүн, Гүйцэтгэх захирал, Ажлын албаны ажилтнуудаас Холбооны хөрөнгөөр хувьдаа ашиг олох зорилгоор бизнесийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно;

5.2.4. Улс төрийн сонгуульд нэр дэвшигчдэд хандив өгөхийг хориглоно.

5.3. Холбооны гишүүний татвар, татварын хувь хэмжээ болон гишүүний татвар хураахтай холбоотой харилцааг энэхүү дүрмийн 5.5-д зааснаар Удирдах зөвлөл нарийвчилсан журмаар тогтоох бөгөөд тодорхой үндэслэлийг гишүүдэд мэдээнэ. Гишүүний татварын хувь хэмжээг тухайн гишүүний Бүх гишүүдийн хуралд оролцох саналын эрхтэй уялдуулан тогтоож болно.

5.4. Холбооны гишүүн нь гишүүний татвараа улирал бүр тухайн улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор төлнө. Гишүүн өөрөө хүсвэл гишүүний татвараа урьдчилан төлж болно.

5.5. Холбооны Гишүүний татвартай холбоотой нарийвчилсан асуудлыг Удирдах зөвлөлөөс “Гишүүнчлэлийн татварын бодлого, журам” баталж зохицуулна.

Зургаа. Төрийн бус байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах

6.1 Өөрчлөн байгуулах, татан буулгах тухай асуудлыг урьдчилан Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, хуралд оролцсон гишүүдийн дөрөвний гурвын саналаар дэмжсэн тохиолдолд бүх гишүүдийн Хурлаар хэлэлцүүлнэ.

6.2. Бүх гишүүдийн Хурлын шийдвэрээр Холбоог хуульд заасан үндэслэлээр өөрчлөн байгуулах буюу татан буулгаж болно.

6.3.Өөрчлөн байгуулсан, татан буугдсантай холбоотой үүсэх эд хөрөнгийн шинжтэй харилцааг Төрийн бус байгууллагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

Г.ИДЭРМАА

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

Р.ОЮУНГЭРЭЛ